



МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД БӨГӨӨД
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/25

Улаанбаатар хот

Аргачлал батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 470 дугаар тогтоолын 1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах аргачлал"-ыг хавсралтаар баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн нэгдсэн бодлогын газар /Л.Балчинлуvsан/-т үүрэг болгосугай.
3. Энэхүү аргачлалыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД Ч.ХҮРЭЛБААТАР



Монгол Улсын Шадар сайд бөгөөд
Эдийн засаг, хөгжлийн сайдын
2023 оны 05 дугаар сарын 08 өдрийн 4/25
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ АРГАЧЛАЛ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид “Холбогдох байгууллага” гэх) нь Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг боловсруулахад энэхүү аргачлалыг баримтална.

1.2. Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөл боловсруулахдаа Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн актад үндэслэнэ.

1.3. Энэ аргачлалд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1. “үндэсний үр дүн” гэж улс оршин байх тулгуур үзүүлэлтэд гарах эерэг өөрчлөлтийг;

1.3.2. “салбарын үр дүн” гэж үндэсний үр дүнг хангах тухайн салбарын тулгуур үзүүлэлтэд гарах эерэг өөрчлөлтийг;

1.3.3. “арга зам” гэж үр дүнг хангахын тулд төрөөс баримтлах үндсэн зарчим, чиглэлийг;

1.4. Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг энэхүү аргачлалын хоёрдугаар хавсралтад заасан загварын дагуу, гуравдугаар хавсралтад заасан цаглаврын дагуу боловсруулна.

1.5. Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дэлхийн хамтын нийгэмлэгийн хүрээнд үүрэг хүлээсэн хөгжлийн бодлогын үр дүн, үр дүнгийн үзүүлэлтийг Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөлд хавсралтаар тусгаж болно.

1.6. Холбогдох байгууллага нь Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын төлөвлөгөөг төсвийн хамт Төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулна.

1.7. Ажлын хэсэг хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах хүрээнд өмнө нь хэрэгжсэн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн гүйцэтгэсэн ажлын тайлан, цаашид анхаарах асуудал, түүнийг шийдвэрлэх боломжийн талаар санал, зөвлөмжтэй танилцаж төлөвлөгөө боловсруулахдаа тусгана.

1.8. Ажлын хэсэг нь холбогдох нөөцийн бэлэн байдлыг хангана.

1.9.1. Хүний нөөц;

1.9.2. Мэдээллийн нөөц;

1.9.3. Санхүүгийн нөөц.

1.9. Холбогдох байгууллага нь Хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн хуулийн этгээдийг оролцуулж болно.

1.10. Ажлын хэсэг нь цаглаврын үе шат бүрд гүйцэтгэсэн ажлыг өмнөх хугацаанд хэрэгжүүлсэн Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагад тайлагнаж шаардлагатай тохиолдолд холбогдох шийдвэрийг гаргуулан ажиллана.

1.11. Ажлын хэсэг нь өмнөх хэрэгжүүлсэн зорилтот хөтөлбөр, түүнтэй адилтгах дунд хугацааны хөгжлийн бодлогын дунд хугацааны үнэлгээ болон урьдчилсан гүйцэтгэлийг холбогдох талуудаар гаргуулан авч боловсруулалтад ашиглана.

Хоёр. Хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах хүрээнд нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх

2.1. Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлын хэсэг нь үндэсний хэмжээнд нөхцөл байдлын дүн шинжилгээ хийнэ. Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх хүрээнд дараах мэдээллийг холбогдох талуудаар гаргуулан авч ашиглана.

2.1.1. Өмнөх хэрэгжүүлсэн зорилтот хөтөлбөр, түүнтэй адилтгах дунд хугацааны хөгжлийн бодлогын үнэлгээ болон урьдчилсан гүйцэтгэл;

2.1.2. Олон улс болон хөрш орнуудын нийгэм, эдийн засгийн төлөв байдлын таамаглал;

2.1.3. Өмнөх 10 жилийн макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, тэдгээрийн динамик өөрчлөлт болон ирэх 10 жилийн төсөөлөл, таамаглал;

2.1.4. Өмнөх 10 жилийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн мэдээлэл;

2.1.5. Өмнөх 10 жилийн мөнгөний бодлогод хамаарах мэдээлэл;

2.1.6. Хөгжлийн тэргүүлэх салбарын өмнөх 10 жилийн нийгэм, эдийн засаг, санхүүгийн үндсэн үзүүлэлтүүд, тэдгээрийн динамик өөрчлөлт болон ирэх 10 жилийн хандлага;

2.1.7. Өмнөх 10 жилийн дотоод харилцааны нөхцөл байдал, иргэдийн харилцааны хандлагын динамик болон ирэх 10 жилийн таамаглал;

2.1.8. Өмнөх 10 жилийн иргэдийн амьжиргаа, ажил эрхлэлтийн хандлагын динамик өөрчлөлт болон ирэх 10 жилийн таамаглал /өмнөх 10 жилийн объектив болон субъектив сайн сайхан байдлын үнэлгээ, нөлөөлөгч хүчин зүйлсийн хамаарлын судалгааны үр дүн/;

2.1.9. Салбарын өмнөх 10 жилийн үр дүн, хөгжлийн хандлага, тэдгээрийн өөрчлөлт болон ирэх 10 жилийн хөгжлийн таамаглал;

2.2. Холбогдох байгууллага нь энэхүү аргачлалын 2.1 дэх хэсэгт заасан мэдээ, мэдээлэл, өгөгдөлд дүн шинжилгээ хийж, Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн гүйцэтгэлд нөлөөлөх шалтгаан, эрсдэлт хүчин зүйлийг тодорхойлж, үнэлэн, эрсдэлийг удирдах арга замыг тодорхойлсон эрсдэлийн суурь судалгааг боловсруулан, Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн танилцуулгад хавсаргана.

2.3. Холбогдох байгууллага нь Хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах хүрээнд тэргүүлэх салбарыг дараах үзүүлэлтийг үндэслэн тодорхойлно.

2.3.1. Нөхцөл байдлын дүн шинжилгээний үр дүн;

2.3.2. Урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүрсэн үр дүн;

2.3.3. Улс орнуудын хөгжлийн хандлага, тэргүүлэх салбар;

Гурав. Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн хүрээнд хүрэх үр дүнг төлөвлөх

3.1. Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн хүрээнд хүрэх үр дүн, тэдгээрийн үзүүлэлтүүдийг Урт хугацааны бодлогын баримт бичиг болон нөхцөл байдлын дүн шинжилгээ, холбогдох талуудаас ирүүлсэн саналд үндэслэн тодорхойлно.

3.2. Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн хүрээнд хүрэх үр дүнг Үндэсний, салбарын гэсэн хоёр түвшнээр ялгаж хооронд нь уялдуулан төлөвлөнө.

3.3. Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн зорилго нь үндэсний үр дүн, зорилт нь салбарын үр дүн байна.

3.4. Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн хүрээнд хүрэх Үндэсний, салбарын үр дүнг кодолно.

3.5. Энэхүү аргачлалын хоёрдугаар хавсралтын “Үндэсний болон салбарын үр дүн, үр дүнд хүрэх арга зам” хэсгийн зорилго хэсэгт Урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилгод үндэслэн Үндэсний үр дүнг тодорхойлж бичнэ.

3.6. Энэхүү аргачлалын хоёрдугаар хавсралтын “Үндэсний болон салбарын үр дүн, үр дүнд хүрэх арга зам” хэсгийн зорилт хэсэгт Урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилтод үндэслэн Салбарын үр дүнг тодорхойлж бичнэ.

3.7. Энэхүү аргачлалын хоёрдугаар хавсралтын “Үндэсний болон салбарын үр дүн, үр дүнд хүрэх арга зам” хэсгийн “Зорилтыг хэрэгжүүлэх арга зам” хэсэгт сонгогдсон арга замыг тусгана. Зорилтыг хэрэгжүүлэх арга замыг энэхүү аргачлалын дөрөвдүгээр хавсралтад тусгасан аргачлалын дагуу хувилбартайгаар боловсруулж, сонгоно.

3.8. Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн хүрээнд хүрэх үр дүн, үр дүнгийн үзүүлэлтийг энэхүү аргачлалын хоёрдугаар хавсралтын “Үндэсний болон салбарын үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин” хэсэгт дараах байдлаар тодорхойлж бичнэ.

3.8.1. “Код” баганад Үндэсний болон салбарын үр дүнгийн кодыг бичнэ.

3.8.2. “Бодлогын үндэслэл” баганад Үндэсний болон салбарын үр дүнд хамаарах Урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилго, зорилтын дугаарыг бичнэ.

3.8.3. “Үндэсний болон салбарын үр дүн” баганад үр дүн, салбарын үр дүнг тодорхойлж бичнэ.

3.8.4. “Шалгуур үзүүлэлт”, “Хэмжих нэгж” баганад үндэсний болон салбарын үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлж бичнэ.

3.8.5. “Суурь түвшин” баганад нөхцөл байдлын дүн шинжилгээний үр дүн, урьдчилсан гүйцэтгэлийн хүрсэн түвшинд үндэслэн суурь он, түвшинг тодорхойлж бичнэ.

3.8.6. “Зорилтот түвшин” баганад нөхцөл байдлын дүн шинжилгээний үр дүн, суурь түвшинд үндэслэн арван жилийн дараа хүрэхээр төлөвлөсөн зорилтот түвшинг дараагийн тав, таван жилээр тодорхойлж бичнэ.

3.8.7. “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад үндэсний болон салбарын үр дүнгийн мэдээллийн бэлэн байдлыг өгөгдсөн үзүүлэлтүүдийн дагуу тодорхойлж бичнэ.

3.8.8. “Шаардлагатай хөрөнгийн хэмжээ” баганад салбарын үр дүнг хангахад шаардлагатай хөрөнгийн хэмжээг төсөвлөнө.


3.8.9. “Үндсэн хариуцагч”, “Хамтран хариуцагч” баганад салбарын үр дүнгийн үндсэн болон хамтран хариуцагчийг тодорхойлж бичнэ.

Дөрөв. Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөлд санал авах

4.1. Холбогдох байгууллага нь төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил болон хуулийн этгээдээс Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөлд санал авна.

4.2. Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөлд ирүүлсэн саналын тусгагдсан байдал, үндэслэл, тайлбарыг санал ирүүлсэн байгууллагад мэдээлнэ.

Монгол Улсын Шадар сайд бөгөөд
Эдийн засаг, хөгжлийн сайдын
2023 оны 05 дугаар сарын 08 өдрийн
дугаар тушаалын гуравдугаар хавсралт



ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ ЦАГЛАВАР

№	Гүйцэтгэх ажил	Хугацаа
1	Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулах	Өмнөх баримт бичгийг дуусгавар болохоос 1 жилийн өмнө
2	Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөл боловсруулах нарийвчилсан төлөвлөгөөг батлуулах	Ажлын хэсэг байгуулагдсанаас хойш 14 хоногийн дотор
3	Энэ аргачлалын 2.1.1-2.1.9-д заасан өгөгдөл, мэдээллийг холбогдох талуудаас авах	Өмнөх баримт бичгийг дуусгавар болохоос 10 сарын өмнө
4	Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх	Өмнөх баримт бичгийг дуусгавар болохоос 8 сарын өмнө
5	Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг боловсруулах	Өмнөх баримт бичгийг дуусгавар болохоос 7 сарын өмнө
6	Холбогдох талуудаас Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөлд санал авах	Өмнөх баримт бичгийг дуусгавар болохоос 6 сарын өмнө
7	Холбогдох талуудаас Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөлд өгсөн саналыг үндэслэлтэй тохиолдолд төсөлд тусгах	Өмнөх баримт бичгийг дуусгавар болохоос 5 сарын өмнө
8	Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг эцэслэн боловсруулах	Өмнөх баримт бичгийг дуусгавар болохоос 4 сарын өмнө
9	Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг холбогдох эрх бүхий байгууллагад танилцуулах	Өмнөх баримт бичгийг дуусгавар болохоос 4 сарын өмнө
10	Ажлын хэсэг нь Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөл боловсруулах хүрээнд гүйцэтгэсэн ажлын тайлан, цаашид анхаарах асуудал, түүнийг шийдвэрлэх боломжийн талаар санал, зөвлөмж боловсруулж оролцогч талуудад нэгдсэн байдлаар хүргүүлэх	Өмнөх баримт бичгийг дуусгавар болохоос 4 сарын өмнө

Монгол Улсын Шадар сайд бөгөөд
 Эдийн засаг, хөгжлийн сайдын
 2023 оны 05 дугаар сарын 08 өдрийн 4/25
 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМЫН ХУВИЛБАР БОЛОВСРУУЛАХ, СОНГОЛТ ХИЙХ АРГАЧЛАЛ

1. Ажлын хэсэг нь зорилтыг /салбарын үр дүн/ хангах арга замыг хоёроос доошгүй хувилбартайгаар боловсруулан, дүн шинжилгээ хийж, сонгоно.

2. Зорилтыг хангах арга зам болон хувилбарын нөлөөллийн урьдчилсан үнэлгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.

3. Хувилбарыг дараах дарааллын дагуу боловсруулж, 1 дүгээр хүснэгтэд заасан загварын дагуу нэгтгэнэ. Хувилбарын дүн шинжилгээний үндсэн судалгаа, тооцооллыг хавсаргана:

- 3.1. Үр дүнг хангах хувилбаруудыг боловсруулах;
- 3.2. Хувилбаруудыг шалгуур үзүүлэлтийн дагуу харьцуулах;
- 3.3. Хувилбар тус бүрийг үнэлж, сонгох.

Хүснэгт 1. Зорилтыг хангах хувилбар боловсруулалт ба хувилбарын шинжилгээ, сонголт хийх загвар

Үр дүн	Хувилбар	Хувилбарыг үнэлэх шалгуур үзүүлэлт	Эрэмбэ
		Нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	
Хувилбарын үнэлгээ			
Авбал зохих оноо		0-2	
Үр дүн 1.	Хувилбар 1.		
	Хувилбар 2.		
Үр дүн 2.	Хувилбар 1.		
	Хувилбар 2.		

4. Боловсруулсан хувилбаруудыг нөлөөллийн урьдчилсан үнэлгээний дагуу тооцоолол хийж, харьцуулан, нийт оноогоор эрэмбэлнэ:

5. Нөлөөллийн урьдчилсан үнэлгээг дараах хүснэгтийн дагуу хийнэ.
- Хүснэгт 2. Нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийх загвар

Үр дүн	Хувилбар	Нөлөө	Үнэлгээ					Нийт оноо
			Хүний хөгжил	Нийгэм	Байгаль орчин	Эдийн засаг	Засаглал	
Үр дүн 1.	Хувилбар 1	Эерэг нөлөөтэй бол	0.4	0.4	0.4	0.4	0.4	2
		Эерэг, сөрөг нөлөөгүй бол	0	0	0	0	0	0

		Сөрөг нөлөөтэй бол	-0.4	-0.4	-0.4	-0.4	-0.4	-2
	Хувилбар 2	Эерэг нөлөөтэй бол	0.4	0.4	0.4	0.4	0.4	2
		Эерэг, сөрөг нөлөөгүй бол	0	0	0	0	0	0
		Сөрөг нөлөөтэй бол	-0.4	-0.4	-0.4	-0.4	-0.4	-2

6. Хувилбаруудын ерөнхий үнэлгээг гаргаж, эрэмбэлэх ба хамгийн өндөр оноо авсан хувилбарыг дэмжигдсэнд тооцно.

Монгол Улсын Шадар сайд бөгөөд
Эдийн засаг, хөгжлийн сайдын
2023 оны 05 дугаар сарын 08 өдрийн 1/25
дугаар тушаалын тавдугаар хавсралт

ҮР ДҮН ХООРОНДЫН УЯЛДААГ ТОДОРХОЙЛОХ АРГАЧЛАЛ

Тухайн бодлогын баримт бичгийн зорилтуудын хоорондын нөлөөллийг 1 дүгээр хүснэгтийн дагуу үнэлнэ;

Хүснэгт 1.Боловсруулж байгаа баримт бичгийн зорилт хоорондын нөлөөллийг үнэлэх загвар

Боловсруулж байгаа баримт бичгийн зорилтууд	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт ...	Дүн (оноог мөрийн дагуу нэгтгэн гаргана)
Зорилт 1					
Зорилт 2					
Зорилт 3					
Зорилт ...					

Хүснэгтийн нүдийг бөглөхдөө мөрт байгаа зорилтуудыг хэрэгжүүлснээр баганад байгаа зорилт тус бүрд нөлөөлөх нөлөөллийг үнэлэх бөгөөд дараах онооны аль нэгийг өгнө. Хүснэгтийн хар нүдийг бөглөхгүй;

Хүснэгт 2.Зорилт хоорондын нөлөөллийг үнэлэх оноо

№	Үзүүлэлт	Оноо
1	Харьцуулж буй зорилтын хэрэгжилтэд хүчтэй эерэг нөлөөтэй	+3
2	Харьцуулж буй зорилтыг хэрэгжүүлэхэд эерэг нөлөөтэй	+2
3	Харьцуулж буй зорилтыг хэрэгжүүлэх нөхцөлийг яваандаа бүрдүүлэх	+1
4	Харьцуулж буй зорилтыг хэрэгжүүлэхэд эерэг болон сөрөг ямар нэг нөлөө үзүүлэхгүй	0
5	Харьцуулж буй зорилтыг хэрэгжүүлэх сонголтуудыг хязгаарлах	-1
6	Харьцуулж буй зорилтыг хэрэгжүүлэхэд сөрөг нөлөөлөх	-2
7	Харьцуулж буй зорилтыг хэрэгжүүлэх боломжгүй болгох хүчтэй эсрэг нөлөөтэй	-3

Сайхантамир Пүрэвээ

From: Нямцэцэг Гантулга
Sent: Monday, May 8, 2023 2:08 PM
To: Сайхантамир Пүрэвээ
Сс: Нямцэцэг Гантулга
Subject: МУ-ын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар танаа - Хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах аргачлал батлах тухай
Attachments: Нямцэцэг Гантулга-2023-05-08T02_55_01.8050310Z_Дашпүрэв Буриад.pdf
Importance: Low

Албан бичгийн төслийн хяналтын карт

Төслийн холбоос:

https://nda6098177.sharepoint.com/:w:/s/MED/docs/EYJO30Jnik9lh_Pt_8M0p1cBexz6jNoD7FPR95YmGrO6nw

Хаана, хэнд: МУ-ын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар танаа

Товч агуулга: Хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах аргачлал батлах тухай

Баталгаажуулсан албан тушаалтнууд:

Мөнгөнсүх Батчулуун 5/4/2023 4:58 PM

Балчинлуvsан Лхагвасүрэн 5/4/2023 4:59 PM

Одончимэг Отгон 5/4/2023 9:06 PM

Дашпүрэв Буриад 5/5/2023 8:51 AM

Мөнгөнсүх Батчулуун 5/5/2023 4:09 PM

Балчинлуvsан Лхагвасүрэн 5/5/2023 4:15 PM

Одончимэг Отгон 5/5/2023 7:02 PM

Дашпүрэв Буриад 5/8/2023 10:54 AM